

ухаан, анагаах ухааныг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. "Хубилай хаан соёлыг дэмжин түгээгч" байсан гэж дүгнэсэн байдаг. Уг номонд XIII-XVI зууны үеийн монголчуудын түүхтэй холбогдох, тэр үед зурагдан үлдсэн зургуудыг Дундад Ази, Европ, Хятад, Монголын архив, музейгээс олж хавсарган оруулсан нь туйлын сонирхолтой болсон бөгөөд зохиогч газар бүрийн зураачид Хубилай хааныг дүрслэхдээ өөрийн ойлголт, төсөөллөөр, тухайлбал Хятадын зураач хятад маягаар, Дундад Азийн зураач Халип, Персийн хаадын дүрээр, Европынхон Марко Поло зэрэг түүхэн гэрчүүдийн өгүүлснийг үндэслэн Европ маягт оруулан дүрсэлсэн байдаг гээд энэ дундаас Хубилай хааны жинхэнэ дүрийг тодруулахыг зорьсон нь Монгол хаадыг хааш нь хамаагүй "чирч" байдаг түүх бичлэгийг шүүмжилж, түүхэн баримтуудыг харьцуулан судалж, нэгтгэн дүгнэснээр сая үнэн рүү дөхнө гэсэн түүх судлалын аргачлалыг хэрэглэжээ.

Уг зохиол Хубилай хааны дүр төрх, амьдрал, төр удирдах арга барил, төрийн гадаад, дотоод бодлогыг дүгнэсэн сурвалж, судалгааны чухал ач холбогдолтой болсон төдийгүй Хубилай хааны тухай төсөөлөл, домог, түүний үйл ажиллагааг аль нэгэн орны үзэл баримтлалд зохицуулан авч үзэх оролдлогуудад шинжлэх ухааны няцаалт өгч чадсан зохиол болжээ.

The issues on relations between Inner Asian nomads and settled China have been highlighted in a great number of research publications written by Russian, Chinese and Mongolian scholars. Positions and point of view of the scholars to the issues of relations between nomads and hun China have different things. In this article author has focused on research works of American scholars Owen Lattimore and Morris Rossabi, who wrote several essential works on the topic.

Author intended to familiarise with main conclusions and concepts of their works. According to the American scholars nomads have their own history, culture and religion. During long time of neighbourhood a specific kind of relationship was established, which confirmed the research of "tribute theory" of the Chinese foreign policy and its evolution. They studied and analyzed the content of major powers policy in the East Asia such as Russia, China, Japan towards Inner Asia as well as American, British and Japanese politics regarding China.

АМЕРИК ДАХЬ МОНГОЛЫН ТАЛААРХИ СҮҮЛИЙН ҮЕИЙН СУДАЛГААНЫ ЗОХИОЛУУДЫН ТОЙМ

МУИС, ОУХС-ийн профессор,
доктор (Ph.D) Н.Алтанцэцэг

АНУ, Монгол улсын хооронд 1987 онд дипломат харилцаа тогтож, Монгол улс ардчилал, зах зээлийн системд шилжих болсноор Америк, Монголын харилцаа нийгмийн бүх салбарыг хамран өргөжин хөгжих болсон юм. Америк, Монголын хамтын ажиллагаа улс төр, батлан хамгаалах, эдийн засаг хүмүүнлэгийн салбарыг хамраад зогсоогүй соёл, шинжлэх ухаан, судалгааны салбарт эрчимтэй хөгжих болсон байна.

Америкийн эрдэмтэд, судлаачид Монголд ирж, Монгол орны байдалтай өөрийн биеэр танилцаж, Монголыг “шинээр” нээх өргөн боломжтой болсон юм. Монгол-Америкийн эрдэмтэд, судлаачид, мэргэжилтнүүд, улс төрчид, дипломатчууд, хувь хүмүүсийн хооронд харилцаа тогтож хамтран ажиллах, харилцан ойлголцох өргөн боломж нээгдсэн юм.

Хэдийгээр арав гаруй жил гэдэг шинжилгээ, судалгааны салбарт урт хугацаа биш ч гэсэн сүүлийн үед Америк болон өрнө зүгийн судлаачид Монголын талаар эрчимтэй судалгаа хийж, Монгол улс, Монголын түүх монголчуудын тухай шинэ шинэ ном, зохиолууд хэвлэн гаргасаар байна.

Америкийн шинжлэх ухааны ололтын нэг онцлог бол тухайн салбарт хийгдэж буй судалгааны оргил бүтээлүүдийг, өөрөөр хэлбэл тухайн салбараар тэргүүлж яваа эрдэмтдийн судалгааг хамруулан нийтэлж, олон нийтийн хүртээл болгох явдал юм. Ингэснээр Америк тухайн салбараар тэргүүлэх төвшинд хүрдэг юм байна. Энэ арга барил нь Монгол судлал дээр ч харагдаж байна. Америкийн судалгааны салбарт ардчилал, өрсөлдөөний систем ч хүчтэй тогтжээ. Монголын түүх, монгол судлалаар тэргүүлж яваа эрдэмтдийн судалгааг олон улсын хурал, семинар зохион байгуулах хэлбэрээр нэгтгэн, хэвлэн гаргах ажлыг эрчимтэй хийж байна.

1987 онд Лондоны Их сургуулийн дэргэдэх Ази, Африк судлалын сургууль “Өнөөдрийн Монгол” сэдвээр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, өрнөдийн орнуудын тэргүүлэх эрдэмтдийг оролцуулжээ. Уг хурлын илтгэлүүдийг 1991 онд Ширин Акинер (Shirin Akiner) хянаж, “Монголын өнөөдөр”¹ нэртэй ном хэвлэн гаргажээ.

Ширин Акинер номын өмнөх үгэндээ “Монгол орон гайхамшигтай бөгөөд өвөрмөц орон... Олон жилийн турш түгжигдмэл байсан нууцлаг орон. Монголчуудыг хамгийн муу мэддэг гэх боловч тэднийг дэлхий дахинд хамгийн сайн мэддэг ... Дунд сургуулийн сурагч бүр монголчуудын

¹ Edit. by Shirin Akiner. “Mongolia today”, Kegan Paul international London and New York, 1991

удирдагч Чингис хааны нэрийг мэднэ. Хятадад Юань гүрнийг байгуулсан Хубилай хааныг мэднэ. Монголчууд Солонгосын хойгоос Персийн булан, Зүүн Европын өргөн уудам газар нутгийг эзлэн, их гүрнийг байгуулж байсан түүхийг дэлхий нийт мэднэ" гэж бичээд энэ үеэс хойшхи Монголын хувь заяа хэрхэн өөрчлөгдсөн болон одоогийн байдлын тухай өргөн олон уншигчид, судлаачдад танилцуулах зорилгоор бичигдсэн эрдэм шинжилгээний дорвитой зохиол болжээ. Энэ номонд Д.О.Морган (D.O. Morgan) "Монголын түүх бичлэгийн асуудлууд"; С.Р. Боуден (C.R. Bawden) "Монгол ба монголчууд"; Т.Н. Хайнин (T.N. Haining) "Кремль ба Форбидден хотын хооронд"; А.Сандарс (A. Sanders) "Өөрчлөлт ба ил тод байдал"; В.И.Батлер (W.E. Butler) "Монгол дахь хуулийн шинэчлэл"; М.Кэйзер (M. Kaser) "Эдийн засгийн хөгжил"; Ж.Г. Иванс (J.G. Evans) "Монголын худалдаа ба хамтын ажиллагаа"; Л.М.Волперс (L.M. Wolpers) "Худалдаа ба хөрөнгө оруулалтын санхүүжилт"; М.Миливожевис (M. Milivojevis) "Монголын ардын арми, цэргийн тусламж ба улс төрийн батлан хамгаалалт"; Б.Сиклос (B. Siklos) "Монголын буддизм"; М.Д. Ивин (M.D. Even) "Монголчуудын бөө мөргөл"; Д.Притчат (D. Pritchatt) "Монгол дахь боловсролын хөгжил"; К.Чаброс (K. Chabros) "Уламжлалт ба орчин үеийн гоёлын ба наамал урлаг" сэдвүүдээр судалгаа хийсэн нь орчин үеийн монголын нийгмийн салбарыг өргөн хүрээтэй хамарсан зохиол болжээ. Уг номонд Монголын түүхийг үе үеэр нь дүгнэн бичсэн нь Монголын түүхэнд орчин үеийн өрнөдийн судлаачдын хандаж буй хандлагатай танилцах боломжийг өгч байгаа юм.

Төв Азийн өргөн уудам нутагт нүүдэллэн оршин тогтнож байсан монголчууд XVIII зууны II хагас гэхэд "хоёр том хөршийн хооронд хуваагдсан бөгөөд хойд болон баруун хэсэг нь Оросын ноёрхолд, өмнөд хэсэг нь Манжийн эзэмшилд орсон юм" гэж дүгнэн үзэж монголчуудыг авч үзэхдээ зөвхөн Монгол улсын хүрээгээр биш буриад, өвөр монголчуудыг хамруулан авч нэгтгэн судалж байгаагаараа онцлог юм. Оросууд буриад Монголын нутагт түрэн орж, хятадууд Өвөр Монголд суурьших болсон нь эдгээр бүс нутгийн монголчуудыг илүү үндсэрхэг үзэлтэй болгосон, Ар Монголд үндсэрхэг үзэл харьцангуй сул байсан хэдий ч 1911 онд тусгаар тогтнолоо сэргээж чадсан (15-р тал) гэх мэтээр дүгнэн бичиж гурав хуваагдсан монголчуудыг харьцуулан судалж дүгнэлт хийжээ.

Уг номын орчин үеийн Монголын тухай судалгаанд Америкийн дэд ерөнхийлөгч Генри Уоллэс (Henry Wallace) 1944 онд Монголд ирж байсан тухай, барууны орнуудаас Английн вант улс БНМАУ-ын тусгаар тогтнолыг анх түрүүн хүлээн зөвшөөрч 1964 оноос Улаанбаатарт Элчин Сайдын Яамаа нээн ажиллуулж, тэр жилдээ найман монгол оюутныг Английн Лидсийн Их сургуульд сургахаар явуулж байсан зэргийг өгүүлсэн нь сонин болжээ. Орчин үеийн Монголын нийгэм, эдийн засгийн байдлыг судлан, Монгол улс түгжигдмэл байдлаас гарсан нь Монголын ирээдүйн хөгжилд ач холбогдлоо өгнө гэж дүгнэсэн байна.

ЗХУ-аар толгойлуулсан социалист систем задран унаснаар Зөвлөлтийн харьяанд байсан Монгол улсын цаашдын хувь заяа хэрхэх нь өрнөдийн болон АНУ-ын судлаачдын сонирхлыг улам бүр татах болсон

юм. Орос, Хятад хоёр орны дунд оршдог зөвхөн Монгол улс ч биш, Оросод харъяалагддаг буриад монголчууд, Хятадад харъяалагддаг өвөр монголчуудын түүх, тэдгээрийн бүс нутагт явагдаж буй өөрчлөлт, үйл явдлыг ажиглан сонирхож, харьцуулан судлахад тэд анхаарлаа хандуулж байна.

1995 оны 2-р сард Америкийн Принсетоны Их сургууль Зүүн Хойд Ази судлалын олон улсын бага хурал зохион байгуулж, XX зууны Монголын зангилаа, сонирхол татсан асуудлаар олон орны эрдэмтдийн санал бодлыг солилцон, шүүн тунгаан хэлэлцсэн байна. Энэ бага хурлын илтгэлүүдийг "XX зууны Монгол"² номонд эмхтгэн гаргажээ. Уг бага хуралд Америкийн Принсетоны Их сургуулийн профессор Стефен Коткин (Stephen Kotkin) / хурлын илтгэлүүдийг нягтлан ном болгон хэвлүүлэн гаргажээ;/ мөн Техас мужийн Християны Их сургуулийн профессор Брус Эй Иллиман (Bruce A. Elleman), Индианы Их сургуулийн туслах профессор Христофер Этвуд (Christopher P. Atwood); Монгол улсаас Шинжлэх ухааны доктор Цэдэндамбын Батбаяр, Ж.Болдбаатар, доктор Гуудайн Төмөрчулуун, Оросын эрдэмтэн Елена Бойкова, Өвөр Монголын эрдэмтэн А.Хүрэлбаатар, Тайваны эрдэмтэн Лан Мэйхуа, Японы эрдэмтэн Наками Тацио, Английн эрдэмтэн Давид Снис (David Sneath), буриадын эрдэмтэн Ичинхорлоо Дугарова, Индианы их сургуулийн Роберт Монтомери (Robert Monthomery), Калифорнийн Их сургуулийн Том Гинсбург (Tom Ginsburg), Мидлвэру Колледжийн туслах профессор Елизабет Ендикот (Elizabeth Endicott) зэрэг эрдэмтэд оролцжээ. Уг номонд Гадаад Монголын талаархи Хятад-Оросын өрсөлдөөн, Гадаад Монголын талаархи олон улсын дипломат бодлого, Өнөөгийн Монгол хэмээх гурван бүлэг сэдвийн хүрээнд эрдэмтдийн өгүүллүүдийг ангилан нийтэлжээ.

Тус ном нь Монголын түүх, орчин үе, олон улсын харилцаа, эдийн засгийн салбарт бага судлагдсан болон зангилаа тулгамдсан асуудлуудыг шинээр хөндөн тавьснаараа онцлог бөгөөд цаг үеийн ач холбогдолтой болжээ.

Монголын нийгэм, монголчуудын амьдрал, тэдний нүүдлийн мал аж ахуйн өвөрмөц онцлогтой салшгүй холбоотой гэдэгт анхааран малчдын амьдрал ахуйг дотор нь орж монгол цай ууж, боорцог идэж, гэрт амьдран судалгаа хийсэн эрдэмтэд бол Америкийн нэрт антропологчид Мелвин С. Голдстейн (Melvyn C. Goldstein), Кантия М.Билл (Cynthia M. Beall) нар юм. Мелвин Голдстейн, Кантия Билл нар 1989-1990 онуудад Монголд 3 удаа ирж, малчдын амьдрал, мал маллах арга барилтай танилцаж, малчдын амьдралд хөдөө аж ахуйн нэгдэл ямар үүрэг гүйцэтгэж байсан, малчид зах зээлд шилжих шилжилтийн үед хэрхэн амьдарч ямар бэрхшээлтэй тулгарч байгаа зэрэгт дүн шинжилгээ хийжээ.

² "Mongolia in the Twentieth Century, Landlocked Cosmopolitan", Edited by Stephen Kotkin and Bruce A. Elleman, M.E. Sharpe, Armonk, New York, London, England. 1999

Тэд “Монголын нүүдэлчдийн өөрчлөгдөж байгаа ертөнц”³ номондоо XIII-XIV зууны Монголын эзэнт гүрний түүхийн үеэс өнөөгийн Монголын түүхийг өгүүлэн бичсэний зэрэгцээ нүүдэлчдийн нийгэм нь газар тариалан эрхэлдэг суурин нийгмийн нэгэн адил түүхийн урт хугацааны туршид хувьсан өөрчлөгдөж, дэвшин хөгжиж ирсэн гэсэн дүгнэлт хийжээ. Монгол улс 1990 оноос Азид улс төр, эдийн засгийн эрс өөрчлөлт хийсэн анхны орон (25-р тал) гэж дүгнэжээ. Судлаачид Алтай уулын хязгаар, Мөст сум, Цагаан бургас хэмээх газар судалгаа явуулж, Мөст сумын амьдрал байдал, үүсч хөгжсөн түүхтэй танилцахдаа малчдын сэтгэгдэл, мал маллах арга барилыг малчдаас өөрсдөөс нь сонсож улмаар өөрсдийн сэтгэгдлээ номондоо бичсэн байдаг. Анх тэд малчидтай танилцахаас өмнө малчид гадаадынханд дургүй байж магадгүй гэсэн болгоомжлолтой байснаа бичиж, өөрсдийгөө америкчууд гэж танилцуулахад анхны уулзсан монгол малчин “Америк-Монголын харилцаа сайжирч байгаа тухай сонссоноо яриад гэртээ урьсан” (29-р тал) үеэс тэдэнтэй дотносон танилцсан тухайгаа бичиж “малчид их сайхан ааш зантай улс” хэмээн дүгнэжээ. Америкийнханд монголчууд “их шулуухан зантай, зочломтгой, тусархаг” (мөн тэнд) санагдсан сэтгэгдлээ бичсэн байна. Тэдний анхаарлыг татсан бас нэг сонин зүйл бол “монголчууд өөхтэй мах, тос хэрэглэснээр өндөр холестеролтой байх гэж бодсон боловч холестеролын хэмжээ 178 мг/дцл байсан нь америкчуудад дундчаар 200 мг/дцл байдаг хэмжээнээс доогуур үзүүлэлттэй байсанд гайхан, ирээдүйд судлах хэрэгтэй асуудал болгон дэвшүүлсэн байдаг (48-р тал).

“Монголын нүүдэлчдийн өөрчлөгдөж байгаа ертөнц” ном нь түүх, антропологийн судалгааны шинжтэй бөгөөд зохиогчид монгол амьдралыг дотор нь орж судалж, үнэлгээ өгснөөрөө судалгаа, шинжилгээний өндөр ач холбогдолтой бөгөөд монголчуудын өвөрмөц амьдрал ахуйг дэлхий нийтэд танилцуулсан чухал зохиол болжээ.

Уг номыг бичихэд гүн туслалцаа үзүүлсэн Шинжлэх ухааны доктор Түмэн (антропологч), ноён Нямдорж нар болон Мөст сумын дарга Пүрэвжав, Хучир бригадын дарга Баянзул, Мөст сумын малчдад талархаж байгаагаа илэрхийлсэн байдаг.

1995 онд “Монгол. Чингис хааны өв залгамжлагч”⁴ ном хэвлэгджээ. Уг ном Монголын түүх, соёлтой танилцуулах зорилготой хэвлэгджээ. Номын эхний хуудсанд Монгол улсын газрын зургийг (хуучин нэрээр) Нийслэл Өргөө, Зүүнгар, Засагт хан, Сайн ноён хан, Түшээт хан, Сэцэн хан аймгийн нутаг дэвсгэрийн зохион байгуулалтаар харуулжээ. Номын дотор талын хуудсанд монгол багийг бүтэн нүүрээр, өнгөт зургаар харуулсан нь Монголын соёлын өвөрмөц байдлыг илтгэн харуулжээ. Уг номыг Патрисиа Бергер (Patricia Berger), Тэрэс. Ц. Бартоломей (Terese Tse Bartholomew) зохиож Жэмес Боссон (James Bosson), Ливайс Р.Ланкастэр

³ Melvyn C. Goldstein, Cyhthia M. Beall. “The Changing World of Mongolia’s Nomads”, University of California press. Berkeley and Angeles, 1994

⁴ “Mongolia. The legacy of Chinggis Khan”, London, New York, 1995

(Lewis R. Lancaster), Моррис Россабис (Morris Rossabi), Хитэр Стодарт (Heather Stoddard) нарын өгүүллэг, судалгаагаар бичигджээ. Зургийг Кузухиро Цурута (Kuzuhiro Tsuruta)-н цуглуулгаар хийжээ. Уг номонд Монголын дүрслэх урлагийн дээжүүдийг Сан Франциско дахь Азийн музей, Монгол улсын номын сан, Үндэсний музейн хадгаламжаас оруулан хэвлэжээ. Уг номыг одоогийн Ерөнхий сайд Намбарын Энхбаярыг Монголын Соёлын Яамны сайдын албыг хашиж байх үед санаачлан, зохион байгуулан хэвлэн гаргажээ. Номонд монголчууд гэж хэн бэ? Яагаад монголчууд гэж нэрлэгдэх болсон тухай, Монгол улс Чингис хаанаас тусгаар тогтнол хүртэл, XVI-XVIII зууны монголын сэргэн мандал, монгол урлагийн тухай танилцуулга, монголын ертөнц дахь бичиг, ном зохиол, гар бичмэл, ном хэвлэл, бурхны урлал, Занабазар зэрэг сэдвүүдийг судлан бичжээ. Монгол бол нүүдэлчдийн ер бусын түүх, соёлын өв залгамжлагч хэмээх дүгнэлтэнд хүрчээ.

Монголч эрдэмтэн Сэчин Жагжид "Монголын сүүлчийн хан"⁵ номоо 1999 онд хэвлүүлэн гаргажээ. Уг номонд Өвөр Монголын улс төрийн зүтгэлтэн Дэмчигдонровын амьдрал, үйл ажиллагаа, тухайн үед Өвөр Монголд өрнөж байсан улс төрийн хөдөлгөөн, Япон, Хятад, БНМАУ тус хөдөлгөөнд хэрхэн хандаж байсан тухай өгүүлжээ.

Сэчин Жагжид энэхүү номондоо монголын түүх судлалд одоо болтол "хориотой" байгаа сэдвийн нэг Ар, Өвөр Монголчууд нэгдэн тусгаар тогтнохын төлөө тэмцэж байсан, энэ тэмцэл нь тухайн үеийн дотоод, гадаад хүчин зүйлээс болоод амжилтанд хүрээгүй түүхийг зоригтой хөндөн бичсэн байна. Зохиогч "Монголын түүхийг үнэн бодит байдлаар, чөлөөтэй бичих хэрэгтэй. Энэ түүхийг бичих боломж Өвөр Монголд байхгүй, Монгол улс ч түүх судлалаа дахин эргэн харах хэрэгтэй. Эрх чөлөөний оронд (АНУ-д -Н.А.) энэ түүхийг бичих боломжтой юм" (16-р тал) гэж бичсэн нь монголчууд түүхээ бичихдээ хойд, урд хоёр хөршийн дургүйг хүргэхгүй, тэдний бодлого, үзэл баримтлалтай зөрчилдөхөөс болгоомжлон, тэр болгон зоригтой хөндөн бичиж чаддаггүйг цохон тэмдэглэсэн байна.

Сэчин Жагжид Дэмчигдонровыг Монголын сүүлчийн хан хэмээн тодорхойлохдоо "Дэмчигдонров (1902-1966) Чингис хааны 31-р үе залгамжлагч байсан бөгөөд энэ зууны (XX зууны-Н.А.) эхний хагаст уугуул монгол газар нутаг нь Хятадын харьяалалд байсан ч Хятадын удирдлагаас чөлөөлөхийн төлөө эцсээ хүртэл тэмцсэн Монголын улс төрийн зүтгэлтэн байсан. Чингис хаанаас хойш Монгол газар нутгаа монголоор нь байлгахын төлөө амь хайрлахгүй тэмцсэн хамгийн сүүлчийн улс төрийн зүтгэлтэн бол Дэмчигдонров юм" гэж дүгнэжээ.

"Монголын түүхийн толь"⁶-ийг Алан Сандерс (Alan J.K. Sanders) зохион хэвлэжээ. Монголын түүхийн он дарааллыг 1162 оноос эхлэн,

⁵ Sechin Jagchid. "The last Mongol Prince" The life and times of Demchigdongrov. Western Washington University, 1999

⁶ Alan J.K. Sanders. "Historical Dictionary of Mongolia", Lanham Md. and London, Published in the USA, 1996

өөрөөр хэлбэл Тэмүүжин төрсөн оноос 1994 оныг дуустал авч үзсэн бөгөөд Монголд болж өрнөсөн үйл явдлуудыг түүхэн он дарааллаар жагсаан бичжээ. Тус номонд шинэ үеийн Монгол улсын улс төрийн зүтгэлтнүүдийн товч намтрыг өгүүлснээс гадна, Монгол улсын төрийн зохион байгуулалт, Их, Бага хурал, Үндсэн хууль, Гадаад хөрөнгө оруулалтын хууль, Монголын Шинжлэх ухааны Академи, Монгол улсын засаг захиргааны хуваарилалтын талаар тодорхой өгүүлсэн нь Монгол улсын талаархи түүхэн ба өнөөгийн тухай мэдлэгийг өргөн олонд таниулах зорилгыг агуулна. Монголыг мэдүүлэх, Монгол улстай танилцуулах зорилгоор "Монголын тухай мэдээлэл"⁷ нэртэй нэвтэрхий толь хэвлүүлсэн байна. Уг нэвтэрхий толийг Монголын Шинжлэх Ухааны Академитэй хамтран зохиожээ. Уг номонд Монголын байгаль, түүх, улс төр, цэрэг, эдийн засаг, нийгмийн бодлого, боловсрол, шинжлэх ухаан, соёл, хэвлэл мэдээлэл, гадаад харилцаа, уламжлал, зан заншил, шашин шүтлэг зэргийг хамруулсан өргөн мэдээлэл, танилцуулгыг олон нийтийн хүртээл болгожээ.

Эдгээр ном бүтээлүүдээс гадна Монголын талаархи судалгаа Америкт хэвлэгддэг эрдэм шинжилгээ, судалгааны сэтгүүлүүдэд өргөн хэвлэгдэж байна. Орон судлал, тив судлал, бүс судлал, олон улсын харилцааны судалгааны чиглэлээр хэвлэгддэг олон сэтгүүл гардгаас үлгэрлэн дурьдвал "Азийн судлал"⁸ сэтгүүл, "Олон улсын харилцааны тойм"⁹ сэтгүүл, "Монголын судалгаа"¹⁰, "Дотоод Азийн судлал"¹¹, "Азийн судалгаа"¹² зэрэг болно.

90-ээд оноос хойшхи арав гаруй жилийн хугацаанд Америк дахь Монгол судлал эрчимтэй хөгжиж, Монголыг "дотроос" нь судлах өргөн боломжтой болж, судалгааны цар хүрээ өргөжин тэлж, Монголын нийгмийн бүх салбарыг хамруулан судалж, дүн шинжилгээ хийх ажил улам эрчимжиж байна. Энэ нь Америк-Монголын харилцаа ойртон нягтарч, хамтын ажиллагаа өргөжин хөгжиж байгаагийн нэгэн илрэл бөгөөд Монгол улс, монголчуудыг судалгааны өндөр төвшинд дэлхий дахинд таниулан ойлгуулахад Америк дахь Монгол судлал чухал үүрэг гүйцэтгэж байна.

Түүх, түүхээрээ өнгөрдөг ч гэсэн тухайн орны түүхэнд хэрхэн хандаж байгаа нь тэрхүү орны тухай ойлголтыг хүүхэд байх цагаас нь толгойд нь хийж, түүн дээр тулгуурлан төрийн бодлого явагддаг тэр улстай харилцах харилцааны үндэс болдог. Ийм ч учраас Монголын түүхэнд хандах хандлага Орос, Хятад, Тайвань, Япон зэрэг орнуудад харилцан адилгүй байдаг бөгөөд түүхэн үнэнийг бичиж, бодит судалгаа хийхэд Америкийн эрдэмтэд зохих хувь нэмрээ оруулж байна. Холын

⁷ Information Mongolia, Perganom Press, 1990

⁸ The Journal of Asian Studies

⁹ Review of International Affairs. East Asian Institute. Columbia University.

¹⁰ Journal Mongolia Survey. A publication of the Mongolia Society.

¹¹ Inner Asian studies, University of Cambridge

¹² Asian Survey

гал авч үзсэн
н дарааллаар
н улс төрийн
улсын төрийн
цаад хөрөнгө
Монгол улсын
н нь Монгол
өргөн олонд
онгол улстай
тэй нэвтэрхий
нжлэх Ухааны
аль, түүх, улс
нжлэх ухаан,
ншил, шашин
олон нийтийн

рхи судалгаа
лүүдэд өргөн
олон улсын
үүл гардгаас
харилцааны
тал"¹¹, "Азийн

Америк дахь
судлах өргөн
х, Монголын
ээ хийх ажил
лцаа ойртон
нэгэн илрэл
шинд дэлхий
чухал үүрэг

үхэнд хэрхэн
йх цагаас нь
явагддаг тэр
с Монголын
рэг орнуудад
дит судалгаа
айна. Холын

Америк ойртон, хаалттай Монгол нээлттэй болсон нь Монгол судлалыг өргөжүүлэн хөгжүүлэх таатай нөхцлийг бүрдүүлж байна.

Монгол улс, монголчуудын түүх, орчин үеийн байдал, түүний гадаад, дотоод асуудалд дэлхийн олон орны судлаачид, эрдэмтэд анхаарлаа хандуулан судлах болсны нэг илрэл нь Америкт хэвлэгдэж буй Монголын тухай судалгааны ном, зохиолууд, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэлүүд юм. Эдгээр ном зохиол, судалгааны бүтээлүүд нь америкчуудад Монголыг үзэх үзэл баримтлалыг төлөвшүүлэх, судалгаан дээр үндэслэн төрийн бодлого явуулах, Монгол улстай харилцах харилцаа, түүнд хандах хандлагын суурь нь болж өгдөг.

Монгол улсын талаархи үзэл баримтлал, түүнд хандах хандлага, бодлого нь Орос, Хятад, Тайвань, Япон, Солонгост харилцан адилгүй байдаг бөгөөд Монгол улс, монголчуудын талаар бодит судалгаа хийж үнэлгээ дүгнэлт өгөхөд жинтэй хувь нэмрээ оруулж байгааг мэдээллийн журмаар товчхон өгүүлэхийг зорилоо.

Since establishment of diplomatic relations between Mongolia and USA in 1987 American scholars and researchers have made intensive studies on Mongolia, its history and people. The article reviews latest significant works published in America such as "Mongolia today" 1991; "The changing world of Mongolia's nomads", 1994; "Mongolia in the 20th century" 1999; "The Legacy of Chinggis Khan" 1995; "The last Mongol Prince" 1999 as well as numerous research articles which help to understand the country by the Americans.